

“ДОРНОД АВТО ЗАМ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 03 сарын 17 өдөр

№ 02

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурал хуралдуулах тухай

“Дорнод авто зам” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай асуудлаар хэлэлцэж, олонхийн саналыг үндэслэн
ТОГТООХ НЬ:

1. “Дорнод авто зам” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022 оны 4 дүгээр сарын 26-ний өдрийн 15 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Бармашын 213 тоотод зарлан хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
 - a. Компанийн 2021 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
 - b. Компанийн аудитын хорооны тайлан, дүгнэлтийг батлах
 - c. 2022 оны ажлын төлөвлөгөөг батлах
 - d. ТУЗ-ийн хараат бус гишүүнийг сонгох
 - e. ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын 2022 оны зардлын төсвийг батлах
 - f. Ногдол ашиг тараах эсэх тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах Бүртгэлийн өдрийг 2022 оны 04 дугаар сарын 05-ны өдрөөр тогтоосугай.
4. Компанийн ээлжит хурлыг хуралдуулах шийдвэр гарсантай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг хүргэхээр 2020 оны 03 дугаар сарын 21-ны өдөр тутмын сонин болон хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр мэдээллэх. Энэ мэдээллийг анх зар хүргэсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа буюу 4 сарын 05-ны өдөр дахин зар гаргахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
5. Ээлжит хурлыг хуралдуулахтай холбогдуулан хурлын дэгийг 01 дүгээр хавсралтаар, хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь энэхүү шийдвэрийн 02 дугаар хавсралтанд заасан бичиг баримттай 2022 оны 03 сарын 25-ний өдрөөс хойш 08⁰⁰-

17⁰⁰ цагийн хооронд “БиДиСЕК” ХК-ийн байранд ирж танилцах эрхтэй болохыг дурьдсугай.

6. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ын агуулгыг 03 дугаар хавсралтаар баталсугай.
7. Хувьцаа эзэмшигчээс “Санал авах хуудас”-ыг хүлээн авах сүүлийн өдрийг харъяалагдах брокер, дилерийн компаниар нь дамжуулан хурал хуралдах өдрөөс ажлын 5-с доошгүй хоногийн өмнө байхаар тогтсугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Ж.Энхболд, Хурал зохион байгуулах комиссын даргаар А.Мягмаржав, Тооллогын комиссын даргаар А.Мягмаржав, гишүүнээр Т.Энхзул тус тус томилсугай.

Төлөөлөн Удирдах

Зөвлөлийн дарга:



Ж.ЭНХБОЛД/